

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ӨМНӨ  
БАТЛАМЖААР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1. Засаглалын бүрэн эрхийн хугацаа буюу 2008-2012 онд аймгийнхаа нийт иргэдийн сайн сайхан аж амьдрал, орон нутгийнхаа хөгжил дэвшлийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулж тус хөтөлбөрөөс аймгийн түвшинд хэрэгжүүлэх 87 зорилт, 161 ажил арга хэмжээг хяналтанд авч биелэлт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон мэдээлж ажиллалаа.

Тайлант онд хяналтанд авсан зорилтуудын биелэлт 106,3 хувьтай байгаа нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилтууд тус аймагт бүрэн хэрэгжих боломжтой гэсэн хэрэг юм.

Биелэлт 100 хувь

2. Аймгийн Засаг дарга төр, засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чанд сахиж Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй мөрдөж ажиллаж байгаа болно.

Биелэлт 100 хувь

3. Төрөөс иргэддээ үзүүлэх үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, ил тод байдлыг хангах үүднээс Баруун-Урт суманд “Нэг цонх”-ны үйлчилгээ нээж Татвар, Нийгмийн даатгал, Халамж, Иргэний бүртгэл, наториат, цагдаа, банкны зэрэг үйлчилгээг нэг дороос үзүүлдэг болсон нь цаг, хөрөнгө хүч хэмнэсэн олны сэтгэлд нийцсэн үйлчилгээ болсон. Энэ үйлчилгээг улам өргөжүүлэх бодлого барьж байна. Түүнчлэн аливаа тендер, төсөл хөтөлбөр, зээл олгох зэрэг иргэдэд үзүүлэх үйлчилгээний сонгон шалгаруулалтанд иргэний нийгмийн төлөөллийг оролцуулж, хяналтын байгууллагуудаар хөндлөнгийн хяналт хийлгэж нийтэд мэдээлдэг ажил хэвшил боллоо. Нөгөө талаар Засаг даргын зөвлөлийн болон хяналт шалгалтын хэсгийн бүрэлдэхүүнд иргэний нийгэм, төрийн бус байгууллагаас төлөөлөл оролцуулж тэдний дуу хоолойг сонсох, саналыг авч гарах шийдвэрт тусгах, иргэдийн дунд санал асуулга явуулж дүгнэлт гаргах зэрэг ажил тогтмол хийгддэг боллоо. Төрийн байгууллагаас гаргаж буй шийдвэр, зохион байгуулсан ажил, мөрийн хөтөлбөрийн биелэлт зэргийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлийг ашиглан тогтмол сурталчилж байгаагийн дээр аймгийн төр захиргааны байгууллагын бодлого, шийдвэр, зохиож буй ажил, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сумдад хэрэгжүүлэх ажлын чиглэл зэрэг шаардлагатай мэдээ мэдээллийг CD бичлэгээр сумдад хүргэж сурталчилж байгаа нь үр дүнгээ өгч байна. Түүнчлэн гол гол мэдээлэл, шийдвэр чиглэлийг аймгийнхаа ВЭБ сайтад тавьж иргэдийн ашиглах, санал бодлоо илэрхийлэх боломж нөхцөлийг хангаж, олон нийтэд хүргэж байна. Баруун-Урт хотод LCD дэлгэц байрлуулж аймаг орон нутгийн чанартай аливаа шийдвэр мэдээллийг нийтэд тогтмол хүргэж байна. Дорнод бүсийн “Талын Монгол” радиотой гэрээ хийж хөдөөгийн иргэдэд хүргэх мэдээллийг 7 хоногт 2 удаа дамжуулж байгаа нь үр дүнтэй ажил боллоо.

Биелэлт 100 хувь

4. Аймаг орон нутгаа хөгжүүлэх, хүн ардынхаа амьдрах таатай орчныг бүрдүүлэх нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн орон нутгийн онцлогт тохирсон бизнесийн таатай орчин бүрдүүлж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцсэн хөгжлийн гарцыг тодорхойлох, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдэнд хөрөнгө оруулалт

хийх боломжийг танилцуулах зорилгоор “Сүхбаатар аймаг-хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулган”-ыг 2010 оны 4 дүгээр сард зохион байгууллаа. Энэ үйл ажиллагааны үр дүнд олон хөрөнгө оруулагчид тодорхой төслүүд хэрэгжүүлэх саналыг тавьж зарим ажлууд хийгдэж эхлээд байна. Тухайлбал : Эрдэнэцагаан сумын нутагт нэг ээлжиндээ 100 хүн хүлээн авах хүчин чадал бүхий аялал жуулчлалын бааз байгуулагдсан, Баруун-Урт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт бага дунд орлоготой иргэдэд зориулсан 150 айлын орон сууцыг барихаар төлөвлөөд 75 айлын сууцыг ашиглалтанд оруулаад байгаа бөгөөд үүний 22,5 хувийн хөрөнгийг гадаадын компани тусламжаар санхүүжүүлж, үлдсэнийг нь гадаадын болон орон нутгийн компаниуд хөнгөлөлттэй хямд өртгөөр барьж байгууллаа. Зөвхөн тусламж дэмжлэгээс гадна 80 орчим ажлын байртай худалдааны төв, 20 шахам ажилчинтай авто вокзал, хүүхдийн тоглоомын талбай, хэд хэдэн орон сууц, сургуулийн хичээлийн байр, 50 ортой эмнэлэг, 8 орчим км авто болон явган зам, 200 орчим машины зогсоол, худалдаа үйлчилгээний талбай баригдаж ашиглалтанд орж мал сүрэг сүүлийн 2 жил дараалан таван төрөл дээрээ өслөө.

Орон нутгийн санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2010 онд нэмэгдсэн өртгийн татвар төлөгч аж ахуйн нэгж 38, иргэн 3, патент болон жишиг татвар төлөгч 99, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэлийн татвар төлөгч 664-өөр тус тус нэмэгдсэн бөгөөд үүнийг дагаж дээрх төрлийн татварын хэмжээ төлөвлөснөөс давж нийт хэмжээгээрээ орон нутгийн төсвийн орлого 7,9 тэрбум төгрөгт хүрч оны эхэнд төлөвлөж байснаас 1,9 дахин давж биелэгдсэн байна. Хууль тогтоомжийн хүрээнд орон нутагтаа төвлөрүүлж болох орлогын эх үүсвэрүүдийг судлан “Бичиг” боомтоор нэвтэрч буй тээврийн хэрэгсэлүүдээс “Байгальтай харьцах эрхийн зөвшөөрлийн хураамж” авах шийдвэрийг ИТХ-аар гаргуулан мөрдөж ажилласнаар 2009-2010 оны 411,4 сая төгрөгийн нэмэгдэл орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Санхүү, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээний төсөвт байгууллагуудын бүртгэл тооцооны ажилтнуудын түвшин тогтоох шалгалтыг онолын, хууль эрх зүйн, практик үйл ажиллагааны гэсэн чиглэлээр авч дүнг гарган холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

2010 онд аймагт арилжааны 3 банк, тэдгээрийн 20 гаруй салбар нэгж ажиллаж аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн бэлэн ба бэлэн бус мөнгөн гүйлгээг хийж, зээлийн эх үүсвэрээр хангах үйлчилгээ үзүүлж байна. 2010 оны байдлаар нийт зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 6,7 тэрбум төгрөгөөр өсч 19,6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оноос 2,0 хувиар буурсан байна. Иргэдийн хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 4.0 тэрбум төгрөгөөр өсч 11,4 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн зээлийн хүү 0,5 функтээр буурсан байна. Дээрх үзүүлэлтүүдээс харахад иргэдийн жижиг бизнес нэмэгдсэн бөгөөд цаашид бодлогын хүрээнд дэмжиж зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлбэл хөрөнгийн эх үүсвэр хуримтлагдсан гэж тооцож болохоор байна.

Орон нутагт ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагууд, бусад бизнесийн төлөөлөлүүдтэй ажил төрлийн уулзалт зохион байгуулах замаар хуулийн хүрээнд хамтран ажиллаж эдийн засгийн өсөлтийг хангах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой байршуулах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүү, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.

5. Аймаг орон нутгийнхаа эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ нийгмийн салбаруудын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлснээр 2010 оны эцэс гэхэд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 77,8, бага боловсролын хамран сургалт 95,5 хувьд хүрсэн нь Засгийн газрын зорилтыг бүрэн хангасан үзүүлэлт юм. Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангалт 97,4-99,2 хувьд хүрлээ. Халзан, Асгат, Наран суманд баригдаж байгаа 320 суудалтай сургуулийн барилга 2011 онд ашиглалтад орсоноор бүх сургууль зориулалтын хичээлийн байртай болох ба дотуур байрын болон цэцэрлэгийн барилгуудад улс, орон нутгийн төсөв, төслийн 1200 сая орчим төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар хийгдэж тоног төхөөрөмж нийлүүлэгдлээ.

Сумдын соёлын төвүүдийн ажилтнуудын 32 хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсны дээр нийт сумдын соёлын төвийн 25 хувь нь мэргэжлийн дээд боловсролтой хүнээр хангагдав. Мэргэжлийн урлагийн байгууллага болон сумдын соёлын төвүүдийг улсын төсөв, төслийн 131 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Мөн аймгийнхаа соёл урлагийн хөгжилийг сурталчлахаар Улаанбаатар хотноо соёл урлагийн өдрүүдийг зохион багуулах бэлтгэл ажил хангагдаад байна. Номын сангуудын материаллаг бааз бэхжиж мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ сайжран цахим үйлчилгээ нэвтэрч байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, эмч дутагдалтай байгаа газруудыг эмчээр хангах арга хэмжээ авч 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт эмнэлгийн мэргэжилтний хангалт 84 хувь, үүнээс аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмчийн хангалтын хувь 100, сум дунд, сумын эмнэлгийн их эмчийн хангалт 80 хувь аймгийн нийт багийн бага эмчийн хангалт 71,8 хувь болж 2008 онтой харьцуулахад нийт эмнэлгийн мэргэжилтний хангалт 2 хувиар, түүний дотор хөдөөгийн багийн бага эмчийн хангалт 13,2 хувиар өссөн байна. Сум болон аймгийн нэгдсэн эмнэлэг стандарт хангасан барилгатай болж, тоног төхөөрөмжийн хангалт 88 хувьд хүрээд байна.

2009-2010 онд нийт 1649 шинэ ажлын байр бий болгож нийтийг хамарсан ажилд 1298 иргэнийг ажиллуулж, ажилгүйдлын түвшин 4 хувь болов.

Сумдын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд зорилт болгон ажилласнаар 2009 онд 212, 2010 онд 269 ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлж, орлогын зохих эх үүсвэртэй болголоо. Ядуурлын түвшин 2009 онд 18,9 хувь байсан бол 2010 оны эцэст 15,1 хувь болж буурсан үзүүлэлттэй байна.

Биелэлт 100 хувь

6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архи дан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн ГХУСАЗЗөвлөл, хуулийн байгууллагуудтай хамтран аймгийн төвд болон сумдад хуулийн байгууллагуудын нээлттэй өдөрлөг, албан тушаалтан иргэдийн дунд сургалт семинар, зөвлөгөөн зохион байгуулах, тодорхой сэдвээр иргэд, төрийн албан хаагчид, оюутан сурагчдад хуулийн сургалт сурталчилгаа явуулах, тэмцээн уралдаан зарлаж дүгнэх, багийн иргэдийн нийтийн хурлаар цагдаагийн тайланг хэлэлцүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гаралтыг бууруулах зорилгоор цагдаагийн байгууллагаас нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах

зорилгоор иргэдийг “Урамшуулалт эргүүл”, аж ахуйн нэгж байгууллагыг “Машинт эргүүл”-д томилон ажиллуулж үр дүнг тооцон ажиллах, архи дан согтуурах явдлыг багасгах зорилгоор бүх сумдад Баасан гаригийг архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, түүнээс татгалзах өдөр болгон хэвшүүлэх, архины хор нөлөө, түүний зохистой хэрэглээний талаар төрөл бүрийн хэлбэрээр сурталчлах, сэрэмжлүүлэг, зураг бүхий гудамжны самбар байрлуулах, шинээр баригдсан болон хөдөөгийн авто замд тэмдэг, анхааруулга танилцуулга суурилуулах, орон нутгийн телевиз FM-ээр шторк нэвтрүүлэх зэргээр хууль хяналтын байгууллагууд, төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллаж байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд 2010 онд 200 гэмт хэрэг гарсан нь 2009 онд гарсан гэмт хэргийн түвшинд байгаа бөгөөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 20 хувиар буурснаас малын хулгайн гэмт хэрэг 50,6 хувь, залилан 4 дахин, бүлгээр үйлдсэн гэмт хэрэг 64,2 хувь, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 10,5 хувиар, баривчлагдсан хүний тоо 11,3 хувиар тус тус буурч, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэлт 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Биелэлт 100 хувь

7. 2010 онд Засгийн газрын 174 тогтоолын 287, 16 хуралдааны тэмдэглэлийн 24, бүгд 198 шийдвэрийн 319 заалтыг бүртгэл хяналтанд авч хэрэгжүүлэх ажлыг хариуцсан мэргэжилтэн, хэлтэс тасаг бүр шат шатандаа зохион байгуулан ажилласнаар дээрх шийдвэрүүдийн биелэлт оны эцэст 89,31 хувийн хэрэгжилттэй дүгнэгдлээ. Засгийн газар, яам, агентлагийн сайд дарга нартай байнгын холбоотой ажиллаж өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрд нь биелүүлж хариу мэдэгдэж тайлагнан ажиллалаа. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхий сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Сангийн, Байгаль орчин, аялал жуулчлалын, Батлан хамгаалахын зэрэг сайд, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах ерөнхий газар, Жижиг дунд үйлдвэрийн газар, Улсын Мал эмнэлгийн газар зэрэг агентлаг, газрын дарга нарт тавьсан олон асуудлууд шийдвэрлэгдэж орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг болсоор байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Батлан хамгаалах яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг олон газартай хамтарч орон нутагт томоохон арга хэмжээ, сургалт семинар зохион байгууллаа.

Биелэлт 100 хувь

8. Энэ зүйлд заасан асуудлаар аймгийн Засаг даргатай холбогдсон ямар нэг асуудал гараагүй бөгөөд Засаг дарга хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Биелэлт 100 хувь

9. Батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг Засгийн газраас баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнаж байна.

Биелэлт 100 хувь

Батламжийг хэрэгжүүлэх талаар 2010 оны түвшинд тавьсан зорилтын биелэлт 100 хувьтай дүгнэгдсэн болно.

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

